



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 04 өдөр

Дугаар

144

Улаанбаатар хот

“МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн
2018 оны үйл ажиллагаа, эдийн засгийн
үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний болон
контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 2.3, 3.1, 3.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 оны үйл ажиллагаа, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний болон гүйцэтгэх захирал Д.Баттөртэй байгуулсан 2018 оны контрактын биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Д.Баттөртэй 2019 онд 1 жилийн хугацаатай контракт байгуулах удирдамжийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд хүргүүлсүгэй.

3.Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0000293